



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалттай холбоотой 136,104,531.00 (нэг зуун гучин зургаан сая нэг зуун дөрвөн мянга таван зуун гучин нэг) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1.“Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.2. Хэрэглэгчдэд үйлчлэх төв, орон сууцны зориулалт бүхий газрыг эрх бүхий этгээдээс олгосон техникийн нөхцөл, ажлын даалгаврыг үндэслэн зориулалтын дагуу ашиглахад дэмжлэг үзүүлэх, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах.

3.“Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Г.Баярсайхан)-т Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2-ийг ханган ажиллаж дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Батлагдсан хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан бол хөрөнгө бэлтгэх зөвшөөрлийг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.3.Компанийн хөрөнгөд бүртгэлтэй, үнэлгээ бүхий газарт хамаарах 44 м² талбай бүхий газрын үнэлгээнд залруулга хийх, төрийн өмчийн мэдээллийн сан, маягтад тусгах;

3.4.Компанийн хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 136,104,531.0 (нэг зуун гучин зургаан сая зуун дөрвөн мянга таван зуун гучин нэг) төгрөгийг

132001105

барагдуулах талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан 2022 оны 14, 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах;


3.5.Компанийн баланс бүртгэлтэй, 28 айлын орон сууцыг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт заасны дагуу захиргааны хэргийн шүүхэд хандан шийдвэрлүүлэх, хөрөнгийг балансаас хасуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх;

3.6.Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дурмийн 5.1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, ашиглалтгүй, маргаантай хөрөнгө, газрын асуудлаар тодорхой ажил зохион байгуулж хэрэгжилтийг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад тогтоолд заасан хугацаанд ирүүлэх;


3.7.Улсын комисс хүлээн авсан, компанийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг эрх бүхий этгээдэд нэн даруй хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.8.Шалгалтын тайланда дурдсан зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Тувшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 06.-ны өдрийн 104. дугаар тогтоолын хавсралт



**“УЛААНБААТАР ДУЛААНЫ СУЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ,
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчлийн утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Компанийн хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төлбөрийг барагдуулаагүй.	136,104,531.00	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022-03-21-ний өдрийн 14, 2022-06-08-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.
2	Компанийн эзэмшил/ашиглалт бүхий газрын үнэлгээнд залруулга хийгдээгүй.	44 м2	Хууль гэрээнд заасны дагуу хариуцлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх.
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021-09-24-ны өдрийн 418 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй.	972 м2	Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэ үнэлгээнд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор судлан саналаа ирүүлэн шийдвэрлүүлэх.
	НИЙТ ДҮН:	136,104,531.00 (Нэг зуун гучин зургаан сая нэг зуун дөрвөн мянга таван зуун гучин нэгэн төгрөг)	

-----оОо-----